



МОНГОЛ УЛСЫН
ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН САЙДЫН ТУШААЛ

2015 оны 04 сарын 20 өдөр

Дугаар 150

Улаанбаатар хот

Ерөнхий мэргэжилтний нэр,
мэргэжлийн салбар зөвлөлийн ажиллах
журмыг шинэчлэн батлах тухай

Монгол улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2, Эрүүл мэндийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, 8.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн салбарын бодлого, хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, эрүүл мэндийн тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангахад дэмжлэг үзүүлэх, мэргэжлийн чиглэлээр зөвлөх чиг үүрэг бүхий орон тооны бус Эрүүл мэнд, спортын яамны ерөнхий мэргэжилтний нэрсийг нэгдүгээр, мэргэжлийн салбар зөвлөлийн ажиллах журмыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Ерөнхий мэргэжилтэн, түүний удирдлага дор ажиллах мэргэжлийн салбар зөвлөлийн үйл ажиллагаанд явцын хяналт тавьж, хагас бүтэн жилээр үнэлгээ өгч ажиллахыг Эрүүл мэндийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /О.Баяр/, Хяналт, шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын газар /Э.Оюунсүрэн/ -т тус тус даалгасугай.
3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайдын 2012 оны 408 дугаар, 2014 оны 239 дүгээр тушаалыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.
4. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг төрийн нарийн бичгийн даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Г.Ганчимэг/-д даалгасугай.

САЙД



Г.ШИЙЛЭГ ДАМБА

080506

Эрүүл мэнд, спортын сайдын
 2015 оны 09 сарын 20 өдрийн
 АСД. дугаар тушаалын 1 дүгээр
 хавсралт

ЭРҮҮЛ МЭНД, СПОРТЫН ЯАМНЫ ЕРӨНХИЙ МЭРГЭЖИЛТНИЙ НЭРС

	Нэрс	Мэргэжил	Албан тушаал	Зэрэг
1	Л.Амгалан	Мэс заслын ерөнхий мэргэжилтэн	УНТЭ-ийн мэс заслын тасгийн эрхлэгч	АУ-ны доктор, клиникийн профессор
2	С.Алтансүх	Яаралтай тусламжийн ерөнхий мэргэжилтэн	УНТЭ-ийн тасгийн эрхлэгч	АУ-ны докторант
3	Ж.Баасанхүү	Нүд судлалын ерөнхий мэргэжилтэн	АШУҮИС-ийн тэнхмийн эрхлэгч	АУ-ны доктор, профессор
4	Ш.Энхтөр	Хүүхдийн ерөнхий мэргэжилтэн	ЭХЭМҮТ-ийн захирал	АУ-ны доктор, клиникийн профессор
5	Л.Ганболд	Эрчимт эмчилгээ, амь тэнссэн үеийн анагаахын ерөнхий мэргэжилтэн	АШУҮИС-ийн багш	АУ-ны доктор, дэд профессор
6	Б.Эрдэнэбулган	Дүрс оношлогоо, радиологийн ерөнхий мэргэжилтэн	ХСҮТ-ийн Ангиографийн тасгийн эмч	АУ-ны доктор
7	Б.Дармаа	Био аюулгүй ажиллагаа, Лабораторийн онош зүйн ерөнхий мэргэжилтэн	ХӨСҮТ-ийн Вирус судлалын лабораторийн эрхлэгч	АУ-ны доктор
8	С.Мөнхбаярлах	Харшил судлалын ерөнхий мэргэжилтэн	АШУҮИС-ийн Анагаахын сургуулийн захирал	АУ-ны доктор, профессор
9	С.Наранцэцэг	Дотрын ерөнхий мэргэжилтэн	УГТЭ-ийн эмчилгээ эрхэлсэн орлогч дарга	АУ-ны доктор
10	Д.Нацагдорж	Уламжлалт анагаахын ерөнхий мэргэжилтэн	Монголын уламжлалт эмнэлэг, сургалтын төвийн захирал	АУ-ны доктор

11	П.Нямдаваа	Халдвар өвчин, нян судлалын ерөнхий мэргэжилтэн	ХӨСҮТ-ийн зөвлөх	Академич, Анагаахын шинжлэх ухааны доктор, профессор
12	Д.Нямсүрэн	Урологийн ерөнхий мэргэжилтэн	УНТЭ-ийн бөөрний мэс заслын зөвлөх	АУ-ны доктор, профессор
13	Р.Шагдарсүрэн	Гэмтэл согог судлалын ерөнхий мэргэжилтэн	ГССҮТ-ийн зөвлөх	АШУ-ны доктор
14	Н.Оюундэлгэр	Цус судлалын ерөнхий мэргэжилтэн	УНТЭ-ийн тасгийн эрхлэгч	АУ-ны докторант, клиникийн профессор
15	О.Батгэрэл	Сэргээн засах тусламжийн ерөнхий мэргэжилтэн	УГТЭ-ийн Эрдэм шинжилгээ, сургалт, хамтын ажиллагаа хариуцсан орлогч дарга	АУ-ны доктор
16	Б.Оюунцэцэг	Нүүр ам судлалын ерөнхий мэргэжилтэн	АШУҮИС-ийн багш	АУ-ны доктор, дэд профессор
17	Д.Өлзийбаяр	Мэдрэл судлалын ерөнхий мэргэжилтэн	АШУҮИС-ийн багш	АУ-ны доктор, дэд профессор
18	Б.Энхжаргал	Эмнэлгийн техник, тоног төхөөрөмжийн ерөнхий мэргэжилтэн	ШУТИС-н ЭХИС-ийн цахилгаан техникийн багш	ТУ-ны доктор, дэд профессор
19	Б.Эрдэнэчулуун	Чих, хамар, хоолойн ерөнхий мэргэжилтэн	ЭХЭМҮТ-ийн зөвлөх, АШУҮИС-н Чих хамар, хоолойн тэнхмийн зөвлөх	АШУ-ны доктор, профессор
20	О.Чимэдсүрэн	Нийгмийн эрүүл мэндийн ерөнхий мэргэжилтэн	АШУҮИС-ийн НЭМ-ийн сургуулийн захирал	АУ-ны доктор, профессор
21	Л.Төмөрбаатар	Эрүүл мэндийн удирдлагын ерөнхий мэргэжилтэн	ХСҮТ-ийн захирал	Удирдахуйн ухааны доктор
22	С.Сонин	Анхан шатны тусламж үйлчилгээний ерөнхий мэргэжилтэн	Монголын Өрхийн анагаах ухааны мэргэжилтэнүүдийн холбооны	АУ-ны доктор, профессор

			ерөнхийлөгч	
23	Д.Энхжаргал	Эм зүй, эм судлалын ерөнхий мэргэжилтэн	АШУҮИС-ийн Эм зүйн сургуулийн захирал	Эм зүйн ухааны доктор, профессор
24	Д.Солонго	Сувилахуйн ерөнхий мэргэжилтэн	АШУҮИС-ийн Сувилахуйн сургуулийн Насанд хүрэгчдийн сувилахуйн тэнхмийн эрхлэгч	Сувилахуйн ухааны доктор
25	Ш.Энхтуяа	Эмгэг судлалын ерөнхий мэргэжилтэн	ЭСҮТ-ийн зөвлөх	АУ-ны доктор
26	Л. Насанцэнгэл	Сэтгэц судлалын ерөнхий мэргэжилтэн	СЭМҮТ-ийн захирал	АУ-ны доктор, дэд профессор
27	Т.Эрхэмбаатар	Эх барих, эмэгтэйчүүдийн ерөнхий мэргэжилтэн	АШУҮИС-ийн Эх барих эмэгтэйчүүдийн тэнхмийн эрхлэгч	Анагаахын шинжлэх ухааны доктор, профессор
28	С.Юндэн	Хор судлалын ерөнхий мэргэжилтэн	Хор судлалын төвийн зөвлөх эмч	АУ-ны доктор
29	Р.Сандуйжав	Хавдар судлалын ерөнхий мэргэжилтэн	ХСҮТ-ийн мэс заслын зөвлөх	Академич, АУ-ны доктор, профессор
30	Я.Энхтөр	Арьс гоо, заслын ерөнхий мэргэжилтэн	АШУҮИС-ийн Арьс судлалын тэнхмийн эрхлэгч	АУ-ны доктор

Эрүүл мэнд, спортын сайдын
2015 оны 04 сарын 20 өдрийн
150 дугаар тушаалын 2 дугаар
хавсралт

МЭРГЭЖЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН АЖИЛЛАХ ЖУРАМ

Нэг. Нийтлэг зүйл

1.1. Эрүүл мэнд, спортын яамны ерөнхий мэргэжилтэн нь / цаашид ерөнхий мэргэжилтэн гэх / эрүүл мэндийн салбарын хөгжлийн чиг хандлагыг тодорхойлох, тухайн мэргэжлийн чиглэлээр бодлого боловсруулах, цаг үеийн тулгамдсан асуудлаар яамны холбогдох газар, хэлтэстэй зөвшилцөн, санал, дүгнэлт, зөвлөмж гаргах, хамтарч ажиллах чиг үүрэгтэй.

1.2. Ерөнхий мэргэжилтэн нь дор дурьдсан шалгуурыг хангасан байна. Үүнд:

- Тухайн мэргэжлийн чиглэлээр нэр хүндтэй, салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн
- Анагаах ухааны доктор болон түүнээс дээш зэрэг, цолтой
- Мэргэжлээрээ 10 буюу түүнээс дээш жил ажилласан
- Ёс зүйн зөрчилд холбогдож байгаагүй
- Ашиг сонирхолын зөрчилгүй
- Дахин томилох тохиолдолд үүрэгт хугацаандаа идэвхи, санаачлагатай ажиллаж байсан зэрэг болно.


1.3. Ерөнхий мэргэжилтэн нь тухайн чиглэлийн туршлага бүхий мэргэжлийн нийгэмлэг, холбоодын тэргүүн, холбогдох эрүүл мэндийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн мэргэжлийн салбар зөвлөл байгуулан ажиллуулна.

1.4. Ерөнхий мэргэжилтэн нь Мэргэжлийн салбар зөвлөлийн бүрэлдхүүн, тухайн жилд хийх ажлын төлөвлөгөөгөө мэргэжлийн чиглэл бүрээр гаргаж, эмнэлгийн тусламжийн хэлтсээр хянуулж, жил бүрийн 1 дүгээр сард багтаан Эрүүл мэнд, спортын сайдаар батлуулж хэрэгжүүлнэ.

1.5. Тухайн жилд хийсэн ажлын тайлангаа жил бүрийн 11 дүгээр сарын 25-ны дотор багтаан холбогдох газар хэлтэст бичгээр өгч, сайдын зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн ажлаа дүгнүүлнэ.

1.6. Ерөнхий мэргэжилтэн, мэргэжлийн салбар зөвлөл нь тогтсон журмын дагуу үйлдсэн тэмдэг, албан бичгийн хэвлэмэл хуудастай байна.

Хоёр. Ерөнхий мэргэжилтний ажлын чиг үүрэг



- 2.1. Ерөнхий мэргэжилтэн нь тухайн мэргэжлийн чиглэлээр хурал, зөвөлгөөнд яамыг төлөөлж оролцох эрхтэй.
- 2.2. Тухайн чиглэлээр салбарын хөгжлийн чиг хандлага, тэргүүлэх чиглэлийг тодорхойлох, хууль эрх зүйн орчинг боловсронгуй болгоход санал өгч оролцох.
- 2.3. Мэргэжлийн чиглэлийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, хүний нөөцийг хөгжүүлэх, тулгамдсан асуудлыг шийдвэрлэх талаар санал, зөвлөмж өгөх, дүгнэлт гаргана.
- 2.4. Холбогдох үйл ажиллагааг яамны захиалгаар гүйцэтгэнэ.
- 2.5. Мэргэжлийн чиглэлээр шинээр гарч буй оношилгоо, эмчилгээ, сувилахуйн стандарт, эмнэл зүйн удирдамж, сурах бичиг, гарын авлагыг боловсруулах, оролцох, хянан тохиолдуулахад оролцоно.
- 2.6. Эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлыг сайжруулах, тухайн мэргэжлийн онцлогийг тусгасан ёс зүйн өвөрмөц хэм хэмжээг боловсруулах, эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хэм хэмжээг мөрдүүлэх талаар санаачлагатай ажиллана.
- 2.7. Эмнэлгийн мэргэжилтний төгсөлтийн өмнөх болон дараах сургалтын хөтөлбөр, мэргэжлийн боловсролын стандарт боловсруулах, мэргэжлийн индексийг боловсронгуй болгоход оролцоно.
- 2.8. Нийгмийн эрүүл мэндийн бодлогыг хэрэгжүүлэхэд дэмжлэг үзүүлж, мэргэжлийн чиглэлээр хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож, санал өгнө.
- 2.9. Тус журмын 1.3 -т заасны дагуу салбар зөвлөлийг бүрдүүлж, тухайн мэргэжлийн чиглэлийн холбоо, мэргэжлийн нийгэмлэгүүдийн үйл ажиллагааг мэргэжлийн арга зүйгээр хангаж, дэмжлэг үзүүлнэ.
- 2.10. Тухайн мэргэжлийн чиглэлээр яаманд иргэдээс ирсэн өргөдөл, гомдлын шийдвэрлэлтэнд оролцох, санал өгөх, газар дээр нь очиж хянаж үнэлэх, дүгнэлт гаргахад оролцоно.
- 2.11. Эрүүгийн байцаан шийтгэх хууль, Шүүхийн шинжилгээний тухай хуульд заасны дагуу хэрэг бүртгэх, мөрдөн байцаах, шүүгчээс хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбогдуулан ирүүлсэн асуудалд мэргэжлийн дүгнэлт гаргахад оролцоно.
- 2.12. Яамны газар, хэлтэс, мэргэжилтнүүдтэй тухайн мэргэжлийн чиглэлээр хамтран ажиллах чиг үүрэгтэйгээр үйл ажиллагаа явуулна.

Гурав. Мэргэжлийн салбар зөвлөлийн ажлын чиг, үүрэг

4.1. Мэргэжлийн салбар зөвлөл / цаашид зөвлөл гэх / нь ерөнхий мэргэжилтний үйл ажиллагааны чиг үүргийг дэмжин ажиллах ба яамнаас гаргах бодлого, явуулах үйл ажиллагаанд мэргэжлийн дэмжлэг, зөвлөмж өгч хамтран ажиллах үүрэгтэй.

4.2. Ерөнхий мэргэжилтэн нь зөвлөлийг байгуулахдаа яамны хариуцсан газар, хэлтэстэй заавал зөвшилцөнө.

4.3. Зөвлөл нь тухайн мэргэжлийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, нийгэмлэг, холбоодын тэргүүн, эрүүл мэндийн байгууллагын төлөөллөөс бүрдсэн 7-11 хүний бүрэлдхүүнтэй байх ба зөвлөлийн гишүүдийн бүрэлдхүүнийг Эрүүл мэнд, спортын сайд баталгаажуулсны үндсэн дээр үйл ажиллагаа явуулна.

4.4. Зөвлөлийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь хурал байна. Гишүүдийн олонхи буюу 75 хувийн ирцтэй тохиолдолд мэргэжлийн зөвлөлийн хурлыг хүчинтэйд тооцно.

4.5. Зөвлөл нь сард 1 удаа хуралдах бөгөөд шаардлагатай тохиолдолд зөвлөлийн даргын шийдвэрээр хуралдаж болно.

4.6. Зөвлөл нь хэлэлцсэн асуудлаараа шийдвэр гаргана. Шийдвэр нь тухайн хэлэлцсэн асуудалтай холбоотой санал, дүгнэлт, зөвлөмж хэлбэртэй байна. Шийдвэрийг ерөнхий мэргэжилтэн гарын үсэг зурж, тэмдэг дарснаар хүчинтэйд тооцож, холбогдох байгууллагад хүргүүлнэ.

4.7. Зөвлөл нь тухайн мэргэжлийн чиглэлээр эрүүл мэндийн байгууллагууд, бодлого боловсруулагчдад анагаах ухааны техник-технологийн дэвшлийг нэвтрүүлэх талаар санал, зөвлөмж өгч, мэдээллээр хангаж ажиллана.

4.8. Эмч, эмнэлгийн мэргэжилтэнд мэргэжлийн зэрэг олгох шалгалтыг зохион байгуулах болон энэ үйл ажиллагааг зохион байгуулж буй бусад холбогдох байгууллагад мэргэжлийн дэмжлэг, туслалцаа үзүүлнэ.

4.9. Холбогдох асуудлаар иргэд, албан тушаалтан, байгууллагаас ирүүлсэн өргөдөл, гомдол, бусад материалыг судлан мэргэжлийн санал, дүгнэлт гаргана.

4.10. Гадаад, дотоодын бусад мэргэжлийн нийгэмлэг, холбоод, ТББ-тай хамтын ажиллагаагаа өргөжүүлэн хамтран ажиллана.

4.11. Улс оронд аюул, гамшгийн байдал тохиолдоход мэргэжлийн чиглэлээр авах арга хэмжээг тодорхойлон, хэрэгжилтэнд биечлэн оролцоно.

4.12. Зөвлөл нь нарийн бичгийн даргатай байна.

4.13. Нарийн бичгийн дарга нь

- Ерөнхий мэргэжилтний зааварчилгаагаар салбар зөвлөлийн үйл ажиллагаатай холбоотой албан бичгийг боловсруулах,
- Зөвлөлийн хурал зохион байгуулах, бэлтгэл ажлыг хангах, хурлын тэмдэглэлийг хөтлөх, хурлаар хэлэлцэх асуудлын материалыг бэлтгэх,
- Ерөнхий мэргэжилтний шийдвэрээр гишүүдэд урамшуулал болон батлагдсан төсвийн гүйцэтгэлийг олгох ажлыг гүйцэтгэх,
- Зардлын тооцоог Эрүүл мэнд, спортын яамны ерөнхий нягтлан бодогчид хүлээлгэж өгөх,

- Мэргэжлийн салбар зөвлөлийн жил бүрийн үйл ажиллагаатай холбоотой албан бичиг, хурлын тэмдэглэл, санал, дүгнэлт, зөвлөмжийг холбогдох зааврын дагуу архивын нэгж болгон бүрдүүлж яамны архивт шилжүүлэх зэрэг үүрэг гүйцэтгэнэ.

4.14. Зөвлөлийн гишүүд нь хуралд санал өгөх эрхтэй оролцох, мэргэжлийн зөвлөлийг төлөөлж ажлын хэсэгт орж ажиллах, эмнэлгийн тусламж үйлчилгээнд шинэ санаа, дэвшилтэт технологийг нэвтрүүлэх талаар санал дэвшүүлж мэргэжлийн зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэх, хэрэгжилтэд биечлэн оролцох, мэргэжлийн нийгэмлэг, холбоодын үйл ажиллагааг уялдуулах, гадаад дотоодын нийгэмлэг, холбоодын туршлагыг өөрийн оронд нэвтрүүлэх, холбогдох шийдвэр гаргахад Эрүүл мэнд, спортын яаманд зөвлөмжлөх чиг үүрэгтэй ажиллана.

4.15. Зөвлөл нь ашгийн төлөө ямар нэг үйл ажиллагаа явуулахгүй, зохион байгуулахгүй.